МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 05 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 2.9 дэх хэсгийг үндэслэн Жендэрийн үндэсний хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Жендэрийн үндэсний хорооны 2021-2023 онд хэрэгжүүлэх онцлох үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, 2021 оны үйл ажиллагааны нийтлэг төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Онцлох үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан асуудлаар салбар, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, мэдээлэл, тайланг улирал тутам Ажлын албанд хүргүүлж байхыг хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3.Хорооны 2021 оны үйл ажиллагааны нийтлэг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрхэлсэн салбар, харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэн ажиллахыг жендэрийн салбар хороо, салбар зөвлөлийн дарга, хорооны гишүүдэд тус тус даалгасугай.

4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний хэмжээнд удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах ажиллах, биелэлтийн мэдээллийг улирал тутам нэгтгэн танилцуулахыг Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Энхбаяр/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ШТТ6091 5498449
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
9019090214
УЛААНБААТАР ХОТ

Жендэрийн үндэсний хорооны 2021 оны
02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ 2021-2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|
| 1 | Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг бэхжүүлэхэд анхаарч, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. | Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо 53.3 хувь байна. | Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 2 | Монгол Улсад хүний эрхийг дээдлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд эрүүдэн шүүдэггүй, хүний эрх зөрчдөггүй улс болох. | - | Олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагууд хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн байна. | ХЭҮК-ын орон тооны гишүүн<br><br>ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 3 | Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, төрийн албан дахь авлига, хүнд суртлыг арилгах, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих замаар сайн засаглалыг хөгжүүлэх. | Монгол Улс Авлигын индекст 111 дүгээрт бичигдэж байна. | Эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх уриалга гарган хэрэгжүүлж, Авлигын индексийг хоёр оронтой тоонд шилжүүлнэ. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар<br><br>Авлигатай тэмцэх газрын дарга<br><br>ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 4 | Төрийн байгууллагын ажлын байрны бэлгийн дарамтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, устгах арга хэмжээ авах. | Судалгаа 1 байна. /ХЭҮК 2019/ | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын тухай хуулийг батлуулна. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар<br><br>Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн |
| 5 | Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах замаар чанартай, урт насалтыг дэмжих, тэдэнд зориулсан хөгжлийн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжилтийг хангах. | Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж насалтын зөрүү 9,7 жил байна. | Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж насалтын зөрүүг бууруулна. | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга<br><br>ЖҮХ-ны Ажлын албаны дарга |

---oOo---

*Жендэрийн үндэсний хорооны 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

ШТТ6091 5498449
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
9019090214
УЛААНБААТАР ХОТ

## ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| **Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх** | | | | | | | |
| 1 | 3.1.2.иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах. | 1 | Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах нөлөөллийн ажил зохион байгуулах. | - | Хууль тогтоомжийн зохицуулалтын байдал | Хууль тогтоомжийн төсөл-1, нөлөөллийн ажил-2 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 2 | 3.1.7.“Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлага”-ыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх. | 2 | Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр, зохистой хөдөлмөр эрхлэлт, ногоон ажын байр; санхүүгийн мэдлэг, бизнесийн ур чадвар олгох гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах. | - | Хэвлэгдсэн гарын авлага Сургалт/оролцогчдын тоо | Гарын авлага-1 Сургалт/оролцогчдын тоо-1/60 | БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 3 | 3.1.9.гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх. | 3 | Эмч, мэргэжилтэнд зориулсан сургалт зохион байгуулах, мэдээлэл сурталчилгааны материал боловсруулах. | ЭМ-50, МС-2 | Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэн, сурталчилгааны тоо | ЭМ-100, МС-3 | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 4 | 3.1.10.эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах. | 4 | Эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан нөхөн сэргээх, зөвлөгөө өгөх загвар төв байгуулах хэрэгцээ шаардлагыг судлах. | - | Судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмжийн тоо | 1 | Үндэсний статистикийн хорооны дарга |
| | | 5 | Нэгдсэн стандарт боловсруулах, эмч мэргэжилтэн бэлтгэх, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан эмнэлэг, кабинет бий болгох. | Эмч мэргэжилтэн-5, аймаг, дүүргийн кабинет-5 | Аймаг, дүүргийн эрэгтэйчүүдийн тасаг, кабинет, эмч нарын тоо | Нэгдсэн стандарт-1, эмч мэргэжилтэн-15, аймаг, дүүргийн кабинет-15 | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 5 | 3.1.11.улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх. | 6 | Улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх. | - | ДШ-ний зөвлөмжийг танилцуулж, сурталчилсан арга хэмжээний тоо | ДШ-ний тайлан зөвлөмж-1, уулзалт-2 | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 6 | 3.1.12.эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах. | 7 | Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах. | Сургалт-3, Оролцогч-100 | Цуврал сургалтад хамрагдагчийн тоо | Сургалт-5, Оролцогч-150 | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| **Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 7 | 3.2.2.жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх. | 8 | Жендэрийн мэдээллийн нэгдсэн санг өргөтгөн төвлөрүүлэх, ашиглах аргачлал болон бусад холбогдох мэдээллийг танилцуулах сургалтууд зохион байгуулах. | - | Сургалт, төрийн албан хаагчийн тоо | Сургалт-3 (Бүс-2, УБ-1) Сургалтад хамрагдсан ТАХ-105 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 8 | 3.2.3.жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах. | 9 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, зорилтот түвшинд хүрсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | 3 | Холбогдох газарт хүргүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн тоо | 4 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 9 | 3.2.5.иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллах. | 10 | Иргэний бүртгэлийн ерөнхий газартай хамтран Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг холбогдох талуудад танилцуулах. | - | дүн шинжилгээний тайлан | 1 | ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 10 | 3.2.7.залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах. | 11 | ХХААХҮЯ-тай хамтран залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг хэлэлцүүлэх. | - | Хэвлэгдсэн тайлан, танилцуулах семинарын тоо | Хэвлэгдсэн тайлан-1, танилцуулах семинар-2 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 11 | 3.2.8.салбарын болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх. | 12 | Салбарын болон орон нутгийн жендэрийн бодлогын хэрэгжилтэд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийх чиглэлээр салбар зөвлөлүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. | 1 | ОСЖҮнэлгээ хийсэн салбар, орон нутгийн жендэрийн бодлогын тоо | салбар-5, орон нутаг-15 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 12 | 3.2.11. салбарын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. | 13 | Салбар, орон нутгийн жендэрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. | салбар-9, орон нутаг-30 | Батлагдсан салбар, орон нутгийн жендэрийн бодлогын тоо | салбар-14, орон нутаг-31 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 13 | 3.2.13.төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах. | 14 | Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх талаар чадавх бэхжүүлэх, аргачлалын төсөл боловсруулах, нэвтрүүлэх ажлыг турших. | 1 | Чадавх бэхжүүлэх сургалтын тоо | 5 | СЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| **Зорилт 3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх** | | | | | | | |
| 14 | 3.3.1.багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах. | 15 | Багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах. | 1 | Жендэрийн асуудлыг тусгасан хөтөлбөрийн тоо | 10 | БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 15 | 3.3.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх. | 16 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх. | БЭМ эрэгтэй-18<br>МТИ эмэгтэй-30 | БЭМ-ийн чиглэлээр суралцагчдын дунд эрэгтэйчүүдийн, МТИ-ийн чиглэлээр суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь | БЭМ эрэгтэй-40<br>МТИ эмэгтэй-40 | БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 16 | 3.3.4.бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах. | 17 | Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах. | Сургалт-1<br>Оролцогч-450 | Сургалт сурталчилгаа, оролцогчдын тоо | Сургалт-3, оролцогч-1000 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 17 | 3.3.5.гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах. | 18 | Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах. | 6 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 10 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 18 | 3.3.6.гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, аймаг, дүүргийн хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэц, хүний нөөцийг бэлтгэх. | 19 | Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, хүний нөөцийг бэлтгэх. | Төв-22, сэтгэл зүйч-39 | Эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэцтэй аймаг, дүүргийн тоо | Төв-22, сэтгэл зүйч-45 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 19 | 3.3.8.хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх. | 20 | Хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжтэй байдалд үнэлгээ хийж тайлан, зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлэх. | - | Хэвлэгдсэн үнэлгээний тайлангийн тоо | 1 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 20 | 3.3.9.сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах. | 21 | Хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах албан тушаалтан болон сэтгүүлч сурвалжлагчдад зориулсан чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах. | - | Сургалтад хамрагдсан УАТушаалтан болон сэтгүүлч, сурвалжлагчдын тоо | УАТ-25, сэтгүүлч, сурвалжлагч-25 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 21 | 3.3.10.жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах. | 22 | “Жендэрийн мэдрэмжтэй мэдээлж сурвалжлах” редакцын бодлого боловсруулах удирдамж боловсруулах, редакцын сургалтууд зохион байгуулах. | - | Боловсруулсан удирдамж, сургалт, оролцогчдын тоо | Удирдамж-1, сургалт-20, оролцогч-400 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| | | 23 | Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх өдрийн хүрээнд жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр нөлөөллийн аян зохион байгуулах | - | Кампанит ажлын тоо /туайн жилээр/ | 3 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 22 | 3.3.12.бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах. | 24 | Олон нийтийн жендэрийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр МҮОНРТ-ийн Гэр бүл сувагтай хамтран ажиллах. | Хамтын ажиллагааны санамж бичиг | Хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | МҮОНРТ-ийн захирал |
| 23 | 3.3.14.нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх. | 25 | Эрүүл, зөв эрэгтэй хүнийг таниулан сурталчилсан агуулга бүхий контент боловсруулж, цацах чиглэлээр Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах. | - | Сурталчилгааны материал, нийтлэл, нэвтрүүлгийн тоо /тухайн жилээр/ | 3 | Монголын эрэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч |

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| **Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | |
| 24 | 3.4.2.Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих. | 26 | ТББ, ИНБ, ХМБ, Хөгжлийн түншлэгчид болон эрдэмтэн судлаачидтай хамтарсан “Цуврал илтгэл танилцуулах, мэдээлэл солилцох” арга хэмжээ зохион байгуулах. | 5 | Хэлэлцүүлгийн тоо | 10 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| | | 27 | "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах" талаарх судалгааны ажлын үр дүн, дүгнэлтийг танилцуулах эрдэмтэн, судлаачдын Үндэсний симпозиум зохион байгуулах. | - | Тэтгэлэг олгосон судалгааны бүтээл, Хэвлэгдсэн сэтгүүлийн тоо | Тэтгэлэгт судалгааны бүтээл-5, Хэвлэгдсэн “Жендэр судлал” сэтгүүл-1 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 25 | 3.4.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх. | 28 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг УИХ болон холбогдох талуудад танилцуулж үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх | Тайлангийн төсөл | Хэлэлцүүлгийн тоо | 5 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| | | 29 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг судлах, хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулах | - | Ажлын хэсгийн тайлан, дүгнэлт | 1 | |
| | | 30 | Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулах | - | ЗГ-ын тогтоолын тоо | 1 | |
| 26 | 3.4.4.төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үндэсний сургагч багш бэлтгэх. | 31 | Төрийн албан хаагчдад зориулсан Анхан, дунд шатны сургалтын модулиар сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах. | 104 | Сургагч багшийн тоо | 155 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| | | 32 | ЖСХ/ГБХ-ийг таслан зогсооход эрэгтэйчүүд, хөвгүүдийг татан оролцуулах удирдамж сургалтын гарын авлага боловсруулах, Төрийн болон ТББ-уудын холбогдох албан хаагчдын сургалт, дадлагын ажилд удирдамжийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх Сургагч багшийн сургалт зохион байгуулах. | - | Сургалтын гарын авлага, сургагч багшийн тоо | Сургалтын гарын авлага-1 сургагч багшийн тоо-25 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 27 | 3.4.6.удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх. | 33 | Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах. | 40 | Сургалтад хамрагдсан удирдах ажилтны хувь (ТТ, ТЗ, УТ, ТҮ) | 65 | Удирдлагын академийн захирал |
| 28 | 3.4.9.жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах. | 34 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх. | - | Сайн туршлагаар хийсэн сурталчилгааны материал /сурталчилгааны тоо | 5 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |

| № | ЖЭТБХҮХ-ийн зорилт, арга хэмжээний дугаар | № | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Суурь түвшин (2020 он) | Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | | Хэрэгжилтийг зохион байгуулах гишүүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 29 | 3.4.10.аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | 35 | Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | - | Тэтгэлэгт хамрагдсан орон нутгийн ТББ, үнэлгээний тайлангийн тоо | 5 | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| **Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 30 | 3.5.2.охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх. | 36 | Охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх. | 81.3 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| 31 | 3.5.3.хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх. | 37 | Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх. | 5 | Мэдээлэл сурталчилгааны аяны тоо, | 7 | ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| **Зорилт 6. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 32 | 3.6.1.улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх. | 38 | Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх. | УТ-2<br>ТЗ-5 | Квотыг хэрэгжүүлсэн улс төрийн болон төрийн захиргааны байгууллагын тоо | УТ-2<br>ТЗ-8 | Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн |
| 33 | 3.6.2.эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах. | 39 | "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нь" төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх | - | Хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөө | Төслийн гэрээ, төлөвлөгөө | ЖҮХ-ны Ажлын албаны дарга |
| 34 | 3.6.3.нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авах. | 40 | Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх. | Удирдамж | Жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлсэн байгууллагын тоо | 31 | Нутгийн өөрөө удирдлагын байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч |

ooOoo